



Мияконожо хотын гадаад иргэдэд зориулсан байгалийн гамшгийн талаарх гарын авлага



Хялбаршуулсан япон хэлний орчуулга



Байгалийн гамшигийн үеийн бэлэн байдал

Хотдоо аюулгүй орчинд ажиллаж амьдрахын тулд уг гарын авлагыг заавал уншина уу!



Эмхэтгэсэн: Мияконожо хот Иргэдийн ахуй амьдрал Соёл урлагийн хэлтэс Гадаад харилцааны тасаг

Хэвлэсэн он: 2022 оны 3 сар

Утас: 0986-23-2295 Факс: 0986-23-3223 Цахим хаяг intl@city.miyakonojo.miyazaki.jp

Хотын захиргааны мэдээлэл

Мияаконожо хотын захиргаа



Гамшгийн үед аюулын дохиолол дуугаргана.



Мияаконожо гадаад харилцааны нийгэмлэг (MIA)



Facebook хуудсаар Англи, Хятад, Монгол хэлээр мэдээлнэ.



Олон хэл дээрх гамшгийн талаарх мэдээлэл



Safety tips гэдэг нь Японд болсон газар хөдлөлтийн талаарх мэдээлэл, цунами-гийн анхааруулга, галт уулын дэлбэрэлт, цаг агаарын мэдээ зэргийн урьдчилсан мэдээлэл авах боломжтой төлбөргүй апплейкшн юм.



Андройд



iPhone бол




NHK WORLD JAPAN

NHK WORLD-JAPAN сувгаас гадаад хэл дээрх мэдээлэл авах боломжтой бөгөөд тус суваг үнэ төлбөргүй.



Газар хөдлөлтийн мэдээний үед

Хүчтэй газар хөдлөлтийн өмнө гар утас болон телевизээр мэдээ дамжуулна. Аюулгүй байдлаа хангах хэрэгтэй. Газар хөдлөлтийн талаар 7-р хуудсыг үзнэ үү.



Зургийг Ус цаг уур, орчны шинжилгээний албаны цахим хуудаснаас авав.

Доорх бэлтгэл хангагдсан эсэхийг тэмдэглэгээ хийж шалгана уу.

Гэр доторх аюулгүй байдал

- Гэр доторх замаа чөлөөлнө.
- Тавилга унахаас сэргийлэх.
- Орох гарах гарцыг хааж юм тавихгүй.
- Унтлагийн өрөөнд тавилга тавихгүй.

Тавилга нурахаас сэргийлэх

- Шүүгээ болон номын тавиур L хэлбэрийн тогтоогчоор бэхлэх
- Гэрэлтүүлэг Гинж болон тогтоогчоор бэхлэх
- Хөргөгч Хана болон багананд тогтоох
- Телевиз Намхан газарт тавих

Тавилганы эргэн тойрон

- Антени болон дээврийн бэхэлгээ
- Цууралтыг засаж Арматурын зэвийг арилгах
- Хагархай үсэрэхээс сэргийлсэн хуулга наах
- Амархан унах газар юм тавихгүй байх
- Шингэн хийн савыг бэхлэх

Гамшгийн үед ашиглах зүйлс

Дэлгүүрт газар хөдөлсөн үед сэргийлэх зорилгоор Гамшгийн үед ашиглах Төрөл бүрийн тогтоогч болон бэхэлгээг худалдаалдаг.

Эндээс Гал командын газрын анхааруулах видео-г үзнэ үү. → Галын аюулын үед шаардлагатай зүйлсийг лавлан харна уу.



Тулаас



Гамшиг тохиолдох үед дараах зүйл бэлэн байгааг хийж шалгах.



Дүрвэх үед (Жишээ)

Том үүргэвчинд хийж бэлдэнэ.

Радио

- Радио
- Баттерей



Эм

- Өвчин намдаагч
- Ходоодны эм
- Наалт
- Түрхдэг тос
- Маск
- Ариутгагч



Бичиг баримт, чухал зүйлс

- Мөнгө
- Банкны дэвтэр
- Тамга
- Жолооны үнэмлэх
- Даатгалын үнэмлэх
- Оршин суугчийн карт
- Паспорт
- Му намбаа карт



Гар чийдэн

- Гар чийдэн (Хүн бүрт нэг ширхэг)
- Баттерей



Бэлэн хоол

- Хоол
- Цаасан аяга тавга
- Лаазалсан бүтээгдэхүүн
- Ус



Бусад

- Хувцас
- Ариун цэврийн хэрэглэл
- Нойтон салфетка
- Дэвсэх зүйл
- Хүнсний скоч
- Нүүр гарын алчуур
- Асаагуур
- Энэ гарын авлага
- Гэрийн шаахай
- Гар утасны цэнэг
- Ванны том алчуур
- Борооны хэрэглэл



Хоргодох байр луу явахдаа авч явах зүйлс (Жишээ)

Гамшгийн үед ус, тог тасрах магадлалтай. Багадаа 3 хоногийн нөөцтэй байх.

Ундны ус

- Савласан ус (Нэг хүн өдөрт 3 л)
- Усны сав



Бэлэн хүнс

- Будаа (Боловсруулсан)
- Лаазтай болон савласан хоол
- Савлагаатай амттан
- Шоколад



Бусад

- Ахуйн хэрэглээний ус (Усанд ордог онгоцонд тосох)
- Алчуур, аяны хөнжил, ариун цэврийн хэрэглэл
- Хоол хийх сав болон данх



Түлш

- Газан плитка
- Газ



Гэр бүлийн гишүүдтэйгээ ярилцах

Аюул осол хэлж ирэхгүй тул байнгын бэлтгэлтэй байх.

- Гэр дотроо хамгийн аюул бага газраа мэдэх
- Хаашаа яаж аль замаар явах ёстой вэ?
- Хоргодох байр луу явах үед юу авч явах ёстой вэ?
- Хоорондоо холбоо хэрхэн барих вэ?
- Уулзах газраа хаана гэж товлох вэ?

Хүнсний нөөцтэй байх

Нөөцлөх
Худалдаж
авах



Он сар хуучин
хүнснээ эхэлж
хэрэглэх

Өдөр тутамдаа хэрэглэх



Жишээ нь: Хүнс, ус, лаазтай газ

Салхи усны аюул болон далайн хар салхи (тайфү)

Японд их хэмжээний бороо орсноос үүдэх гамшиг болон хар салхиний аюул жил бүр нүүрлэдэг тул цаг агаарын мэдээ сонсож хариу арга хэмжээ авахад бэлэн байх.

Их хэмжээний бороо орсон үед яах ёстой вэ?

Урьдчилан сэргийлэх мэдээ

Хөрс нурах болон усанд автах үед



Цаг уурын онцгой мэдээ

Их хэмжээний борооны улмаас хөрсний гулсалт болон усанд автах эрсдэлтэй үед

Цаг уурын онц ноцтой мэдээ

Хэдэн арван жилд нэг удаа ордог их хэмжээний бороо гэж үзсэн үед

Баталгаатай эх сурвалжаас үнэн бодит мэдээлэл авсны дараа шуурхай үйлдэл хийх

Ширүүн аадар бороо Богино хугацаанд орох аадар борооны талаар цаг уурын албанаас Анхааруулдаг ба Миязаки-д 1 цагт 120 мм-ийн хур тунадас орсон байдаг.

Хур тунадасны хэмжээ болон орох байдал	1 цагт орох хэмжээ	10-20 мм	20-30 мм	30-50 мм	50-80 мм	80 мм дээш
	Ямар үгээр илэрхийлдэг болох	Бага зэргийн хүчтэй бороо Яаа цүй амэ	Хүчтэй бороо Цүй амэ	Ширүүн бороо Хагэший амэ	Маш ширүүн бороо Хижёони хагэший амэ	Онцгой ширүүн бороо Моорэцүна амэ

Тайфү болсон үед цаг агаарын анхааруулах мэдээний дагуу арга хэмжээ авна уу.

Тайфү-ны хэмжээ болон хүч

Хэмжээ (Салхины хурд 15м/сек-ээс дээш)	500-800 км	800 км дээш	Хүчтэй (Хүчтэй салхины хурд)	33-44 м/сек	45-54 м/сек	55м/сек -ээс дээш
Телевиз радиогоор хэрэглэгдэх үг	Хүчтэй Оогата	Маш хүчтэй Чёо оогата	Телевиз радиогоор хэрэглэгдэх үг	хүчтэй цүйой	маш хүчтэй хижёони цүйй	онцгой хүчтэй моорэцүна

Аадар бороо

Борооны улирлын дараа тохиолдох нь элбэг байдаг. Урьдчилан мэдэх боломж маш бага байдаг. Гэнэт богино хугацаанд их хэмжээний устай бороо ордог. Аадар борооны улмаас голын ус эргээс халих, хөрс нурах, гулсах зэрэг аюулт үзэгдэл болдог. Цаг уурын мэдээ анхааралтай сонсох ёстой. Газар доорх болон нам газрын зам ашиглахаас зайлсхийх. Авто замын болон төмөр замын метро зэрэг болно. Борооны улмаас зам хаагдах магадлалтай. Мияконожо хотын хувьд Минамитакао, Нишимача, Ямадамичи Накакиришима, Яманогүчи Ханаги орчмыг нэрлэж болно.



Эрэг халих

Хур тунадас их хэмжээгээр орсноос үүдэн гол мөрөн эргээс халих үзэгдлийг гадны нөлөөлөлөөс үүдэх эрэг халилт, хот тосгоны ус зайлуулах системээс үүдэлтэй буюу замын доороос ус гарсан бол дотоод хүчин зүйлээс нөлөөлсөн эрэг халилт гэж хоёр хуваана.

Гадны нөлөөлөлтэй ус халилт

Усны түвшин огцом нэмэгддэг тул анхаарах



Дотоод нөлөөлтэй ус халилт

Урьдчилан таамаглаж анхааруулах дохио өгөхөд хэцүү тул анхаарах шаардлагатай



Гол мөрний ус халих болон урьдчилан сэргийлэх

Тухайн гол мөрний усны хэмжээний аюултай түвшин гэж байдаг. Улсын болон мужийн цахим хуудаснаас мэдээлэл авч болно. Мияконожо хот аюултай түвшинд ирлээ гэж үзсэн тохиолдолд гэр орноосоо дүрвэж аюулгүй газар очих зааварчилгаа өгдөг. (хуудас 10)

Оёодо голын усны түвшингийн талаарх мэдээлэл 「Гол усны аюултай байдлын мэдээлэл」
<https://www.river.go.jp/portal/?region=80&contents=multi>



<http://kasen.pref.miyazaki.jp/index.html>



Гол мөрөн	Хэмжилт хийдэг газар	Хэмжилт тохиргооны усны түвшин	Эрэг халих анхааруулах түвшин	Дүрвэх хэмжээний усны түвшин	Эргээс халих аюултай түвшин
Оёодо гол	Такэшта (Улс)	3.20	3.70	4.10	4.80
Окимизү гол	Окимизү гүүр	2.50	3.20	4.10	4.40
Марутани гол	Кошюү гүүр	2.20	3.30	3.30	3.60
Такасаки гол	Такасаки гүүр	0.10	0.90	0.90	1.20
Хигаши дакэ гол	Ойда гүүр	2.00	2.30	2.30	2.50
Хагивара гол	Эйгэнжи гүүр	0.20	1.70	1.70	2.50

Хөрснөөс үүдэлтэй гамшиг

Их хэмжээний хур тунадас орсны дараа, том хэмжээний байгалийн гамшиг тохиолдох нь элбэг.

Хөрсний нуралт, гулгалтын үед цацагдах мэдээ (мэдээний түвшин 4)


Амь насанд аюултай хөрсний нуралт болон гулсалт үүсэх үед зарладаг урьдчилан сэргийлэх мэдээ. Их хэмжээний хур тунадас орсны дараа уг мэдээ зарлагдана.

Хөрсний гулгалтын гамшиг болон гамшгийн өмнө тохиолддог зүйлс

Байдал хэвийн бус байгааг мэдмэгц аюулгүй газар луу явах. Энгийн үед гамшгийн үед хаагуур яаж явж, аюулгүй газарт очих боломжтой эсэхээ урьдчилан шалгах хэрэгтэй.

Гулсалт

Хөрсний гулсалт гэнэт үүсдэг тул аюулгүй газарт зугтаж амжилгүй хохирогч ихээр гардаг.




Нуралт

Их хэмжээний борооны улмаас чулуу болон шороо ихээр нуран урсдаг. 1 цагт 20-40 км хурдтай байдаг тул агшин зуурт байшин урсдаг.



Суулт

Гадаргуу аажмаар доош сууна. Суулт өгөх гадаргууны хэмжээ их хэмжээний талбайг эзэлдэг тул хохирлын хэмжээ ихэсдэг.



Газар хөдлөсөн үед яах ёстой вэ?

Газар хөдлөлт !

1-2 минут

3 минут

5 минут

10 минутаас хойш

Ойролцоогоор томоохон хэмжээний чичирхийлэлт 1 минут орчим байна.

Өөрийгөө хамгаалах, ялангуяа толгойгоо сайн хамгаалах хэрэгтэй.

Гал унтраах.

Хүчтэй чичирхийлэх үед гадагш аюулгүй газарт очих.

Чичирхийлэлт дуусахаар

Зугтах үед эргэн тойронд аюултай зүйл байгаа эсэхийг шалгах

Хэрэв гал гарсан бол галыг унтраах.

Гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг шалгах.

Гутлаа өмсөх. (Гэр дотор шилний хагархай байх магадлалтай)

Бүх хүн аюулгүй байгааг шалгах (хүүдас-8)

Дараагийн чичирхийлэлээс сэргийлэх.

Хөршөө аюулгүй байгааг шалгах.

Ойр орчмын хүмүүсийн аюулгүйг байгааг лавлаж, туслах.

Үнэн зөв мэдээлэлтэй байх

Мэдээлэл нягтлах Цуу, баталгаагүй мэдээнд итгэхгүй байх. 119 дугаараас өөр дугаар луу утсаар ярихгүй байх.

Бүгд хүчээ нийлүүлж гал унтраах

Үнэн зөв мэдээлэлтэй байх, нурсан байшинд орохгүй байх.

Барилга байшингийн дотор байх үед

Өндөр барилга

- Хаалга болон цонхоор дамжин гарах
- цахилгаан шат ашиглахгүй байх
- Шат ашиглах

Их дэлгүүр болон заал

- Шилнээс хол байх
- Багана болон хананд ойр байх
- Ажилтаны зааврыг сонсох

Цахилгаан шат

- Бүх товчийг дарж хамгийн ойр давхарт зогсох
- Тусламж дуудах товчлуураар холбоо барих
- Биеийн хүчээ нөөж тусламж хүлээх

Барилга байшингийн гадна талд байх үед

Алхаж байх үед

- Цонхны шил болон зарлалын самбар блокон хашаанаас холдоно.
- Байшингаас хол зайтай газарт очих
- Цахилгааны шон болон цахилгааны шугамнаас болгоомжлох

Машин жолоодож байх үед

- Хурдаа хасаж замын зүүн талд зогсох ба машинаа унтраана.
- Түргэн тусламжийн машин явах зам чөлөөлж зогсох
- Чичирхийлэл зогсох хүртэл хүлээх

Хоргодох байр луу явах үедээ

- Түлхүүрээ машин дотор тавих
- Машины бичиг баримтаа авах
- Хаалгаа цоожлохгүй
- Машинаас буух

Далайн ойролцоо

- Цунами ирэх магадлалтай
- Өндөр газар луу зугтах
- Цунами-гийн мэдээлэлтэй байх
- Далайн эргээр явахгүй байх

Галт тэрэг

- Зогсож явах үеийн бариулаас барих
- Ажилтны зааврыг сонсох
- Дураар гадагш гарахгүй байх

Ганцаараа гал унтраах гэж оролдож болохгүй. Эргэн тойрныхоо хүмүүст мэдэгдэх. 119 дугаарт залгах. Гал унтрааж чадахгүй үед зугтах хэрэгтэй.

Галын аюулын үед хийх зүйл

1

Түргэн мэдэгдэнэ.

「Кажида!」 гэж чангаар хашгирна. Дуу гарахгүй бол түмпэн сав балбаж чанга дуу чимээ гаргана. Бага зэргийн гал байсан ч 119 руу залгана.

2

Галаа түргэн унтраана.

Сандлын зөөлөвч дэвсгэрээр галыг цохих болон хөнжил бүтээлэг дэвсэж гал унтрааж болно.

3

Түргэн зугтана.

Гал таазанд хүрмэгц тухайн галыг ганцаараа унтраах боломжгүй болно. Зугтах хэрэгтэй. Гал гарч буй өрөөний хаалга цонхыг хааж зугтана.



Гал унтраах хэрэгсэл байхгүй үед гал унтраах арга

Тостой сав

- Ус хийж огт болохгүй
- Норгосон том алчуур урдаас нь бүтээж нөмөргөнө.

Зуух

Усанд дүрсэн алчуураар урдаас нь бүтээнэ.

Хувцас

Өнхөрч галаа унтраана. Үсэнд гал авалцахаас сэргийлж алчуураар толгойгоо бүтээнэ.

Газ ашигладаг шүршүүр

Хаалгаа огцом онгойлгохгүй Газны үүсвэрийг хааж, хаалгаа бага багаар нээж шүршүүрийн өрөөнөөс гарна.

Цахилгаан бараа

Тог цохих магадлалтай тул шууд ус цацахгүй. Цахилгааны утсыг залгуураас салгана. Гал хамгаалагчаа унтраана.

Хөшиг, өрөө хуваагч хана

Татах, урах зэргээр таазанд гал авалцахгүй байх үйлдэл хийнэ.

Гал унтраах хэрэгсэлийн заавар

1. Тагийг онгойлгох
2. Хоолойг гал руу чиглүүлэх
3. Бариулыг чанга атгах



Бичлэг
Мияаконожо хот Гал командын газрын гал унтраах хэрэгсэл ашиглах заавар
<https://youtu.be/TOABPxIP1w>




Орон байрны галын дохиолол

Гал гарсан үед дохиолол дуугарна.

Дараах хэсгүүдэд заавал байрлуулсан байх шаардлагатай.

- Унтлагны өрөө
- Шат

Галын дохиолол хэвийн ажиллаж байгаа эсэхийг жилд нэг удаа заавал шалгаж байх ёстой.






Галт уул дэлбэрэх аюулыг сэрэмжлүүлэх мэдээ

Киришима уул өнөөг хүртэл хэд хэдэн удаа дэлбэрч байсан.

Одоо ч галт уул идэвхтэй хэвээр байгаа.

Киришима уул дэлбэрсэн тохиолдолд хэрхэн ямар арга хэмжээ авах ёстой тухайгаа урьдчилж мэдсэн байх ёстой.

Төрөл	Нэршил		Хамрах хүрээ	Түвшин		Галт уулын байдал	Аюул нүүрлэсэн үед
Тусгай сэрэмжлүүлэх мэдээ	Галт уулын дэлбэрэлтийн талаарх мэдээ (Оршин суудаг бүс нутгийг хамарсан)	噴火警報 (居住地)	Дэлбэрэлтийн голомтоос оршин суугаа дүүрэг хүртэлх бүс нутаг	5	Зугтах 	Оршин суудаг бүс нутагт гамшгийн хэмжээний галт уул дэлбэрэх болон дэлбэрч болзошгүй тохиолдолд	<ul style="list-style-type: none"> • Сандрахгүй • Хотоос өгөх зааврыг сонсох • Газ-аа хаах • Ойр орчмын хүнд туслах • Гэрээ цоожлоод дүрвэх байр луу явах
	эсвэл	Функа кэйхоо (Кёжүү чийки)					
Сэрэмжлүүлэх мэдээ	Дэлбэрэлтийн талаарх мэдээ (дэлбэрэлтийн голомт болох бүс нутгийг хамарсан)	噴火警報 (火口周辺)	Өргөн хэмжээг хамарсан дэлбэрэлтийн голомт	3	Ууланд гарахыг хориглох 	Оршин суудаг бүс нутагт гамшгийн хэмжээний галт уул дэлбэрэх болон дэлбэрч болзошгүй тохиолдолд	<ul style="list-style-type: none"> • Үнэн бодит мэдээлэл авах • Баримтгүй мэдээлэлээс болгоомжлох • Дүрвэх бэлтгэлтэй байх • Хуурамч хөдлөлт болон унаж ирэх чулуу шорооноос болгоомжлох ※ Бүс рүү орсон үед амь насанд аюултай.
	эсвэл	火口周辺警報					
Урьдчилан сэргийлэх мэдээ	Дэлбэрэлтийн талаарх урьдчилан сэргийлэх мэдээ	噴火予報	дэлбэрэлтийн голомт	1	Идэвхтэй галт уулнаас болгоомжлох 	Нам гүм. Галт уулын эргэн тойронд галт уулын үнс байдаг.	2-р түвшингийн байдалд бэлэн байх (хуу-3)

Ус цаг уур, орчны шинжилгээний албаны цахим хуудаснаас

https://www.data.jma.go.jp/svd/vois/data/tokyo/STOCK/kaisetsu/level_toha/level_toha.htm

Цаг уурын анхааруулах мэдээ (Түвшин 1)-ний үед Дүрвэх байр болон тухайн байр луу очих замаа мэдсэн байх
• Дүрвэх байр луу явах үед авч явах зүйлс (хуу-3)

Дүрвэх байрны мэдээлэл болон анхааруулах дохионы түвшин

Дүрвэх гэдэг нь гамшиг болсон үед тухайн голомтоос холдон явахыг хэлнэ.

Хотоос үер усны аюул болон хөрсний үүдэлтэй аюул гамшгийн үед (хуудас 4-6)

「Дүрвэх мэдээлэл」 болон 「Аюулгүй байдлын түвшин」 үеийн сэрэмжүүлэх мэдээлэл өгнө.

Аюулгүйн 5 түвшин байдаг. Аюулгүйн түвшин 4 гэсэн ангилалд хүрэхээс өмнө заавал дүрвэнэ үү.

Далайн хар салхи болох тайфү болон их хэмжээний бороо орох үед урьдчилан сэргийлэх

боломжтой. Дүрвэх болсон тохиолдолд хэрхэн яаж дүрвэх төлөвлөгөө гаргана үү.

Аврах түвшний байдал	Мэдээ ① Хотын захиргааны мэдээ ② Усанд автсан гамшгийн мэдээ ③ Үргэжилсэн бороо ус болон хөрсний үүдэлтэй холбоотой аюул			Бэлтгэл арга хэмжээ	Урьдчилж төлөвлөгөө гаргаж бичиж бэлдэх
	Монгол хэл	Япон хэл	Галиг		
Түвшин 1 Цаг агаар муудна	① - ② - ③ Цаг уурын шуурхай мэдээ	① - ② - ③ 早期注意報	① - ② - ③ Сооки чүйхоо	Гарын авлага болон цахим хэлбэрийн мэдээлэлээс гамшгийн үед авах арга хэмжээг судалж, бэлтгэл хийх.	Жишээ) Дүрвэх үеийн хүнсний бэлтгэл _____ _____ _____
Түвшин 2 Цаг агаар муудна	① - ② Эрэг халих анхааруулах дохио ③ Их хэмжээний борооноос үүдэх үерийн дохио	① - ② 氾濫注意報 ③ 大雨洪水注意報	① - ② Ханран чүйхоо ③ Ооамэ коозүй чүйхоо	Гарын авлага болон цахим хэлбэрийн мэдээлэлээс гамшгийн үед авах арга хэмжээг судалж, бэлтгэл хийх.	Жишээ) Өөрийгөө хэрхэн дүрвэх талаар бичих Дүрвэх байр хаана очих : _____ Хэдэн минут _____ мин
Түвшин 3 Байгалийн гамшиг болж болзошгүй	① Өндөр настан дүрвэх ② Эрэг халих анхааруулах дохио ③ Их хэмжээний бороо орохыг анхааруулах дохио	① 高齢者避難 ② 氾濫警戒情報 ③ 大雨警報	① Коорэйшя то хинан ② Ханран кэйкай жёохоо ③ Ооамэ кэйхоо	Дүрвэх үед бусад хүмүүсээс илүү цаг орох бол түргэн зугтах ! ※Өндөр настан болон бага насны хүүхэдтэй хүмүүс	Жишээ) Дүрвэж эхлэх _____ _____ _____
Түвшин 4 Байгалийн гамшиг болно	① Дүрвэх удирдамж ② Эрэг халих Сэрэмжлүүлэх дохио ③ Хөрснөөс үүдэлтэй гамшгийн анхааруулах дохио	① 避難指示 ② 氾濫危険情報 ③ 土砂災害警戒情報	① Хинан шижи ② Ханран ③ Дошя Сайгай кэйкай жёохо	Аюултай газраас дүрвэх Бүс нутгийн мэдээ 4-р түвшинд хүрвэл заавал дүрвэх	Жишээ) Дүрвэх байранд SafetyTips апплейкшинаар дамжуулж мэдээлэлтэй байх _____ _____
Түвшин 5 Одоо гамшиг болно. Гамшиг боллоо.	① Аюулгүй байдлаа хангах ② Ус эргээс халих ③ Их хэмжээний борооны мэдээлэл	① 緊急安全確保 ② 氾濫発生情報 ③ 大雨特別警報	① Кинкю анзэн какүхо ② Ханран Хассей Жоохо ③ Ооамэ Токубэцү Кэйхо	Аюулгүй байдалд дүрвэх боломжгүй. Амь насанд аюултай Амь насаа хамгаална үү.	Жишээ) Дүрвэх байранд очихоороо өөрийнхөө байр байдлыг гэр бүлийнхэн болон найз нөхөддөө дамжуулах. _____ _____

Дүрвэх үед яах ёстой вэ?

Дүрвэх гэдэг нь дүрвэх байр луу явах үйлдлийг хэлж буй явдал биш гэдгийг анхаарна уу. Дүрвэнэ гэдэг нь аюултай газраас зугтахыг хэлнэ. **Орон гэртээ байх нь аюулгүй тохиолдолд дүрвэх байр луу явах шаардлагагүй.** Ойролцоо амьдардаг найзынхаа гэрт очиж дүрвэсэн ч болно. Гадагшаа гаралгүй өөрийн гэрийн хоёр дугаар давхарт гарч дүрвэж болно.

Доорх тохиолдолд ① Гадагшаа гарахгүй ② Дээд давхарт гарах ③ Тусламж хүлээх
Жишээ нь :

- Харанхуй болсон болон их хэмжээний борооноос гадна орчны үзэгдэх байдал муу үед
- Ус өвдөгнөөс дээш татсан, алхахад аюултай үед
- Усны урсгал ширүүсэж алхахад хүндрэлтэй болсон үед



Нягтлах

- Өөрөө өөрийнхөө амь насыг хамгаалах үүрэгтэй.
- Гамшиг болсон үед таны гэр орон аюулгүй эсэхийг нягтлах шаардлагатай.

Дүрвэх үед хэрхэн яах ёстой талаар

Таны хийх үйлдэл?

Гамшгийн эрсдэлийн зураг (Hazard map)
※өөрийн гэр байгаа байршилд тэмдэглэгээ хийх.

Өөрийн гэр байгаа хэсгийг өнгө будгаар тодруулж ялгасан эсэх?

Үгүй

Тийм

Гамшгийн үед аюултай. Гамшгийн үед өөрийн гэрт байх биш, дүрвэх байр луу очих.

Ховор тохиолдолд

Дүрвэх үед танд хир цаг шаардлагатай вэ? Өндөр настан, бага насны хүүхэд бий эсэх

Үгүй

Тийм

Аюулгүй газарт амьдардаг найз бий юу?

Тийм

Үгүй

Анхааруулах түвшин **3** болсон үед найзын гэр лүү дүрвэх

Анхааруулах түвшин **3** болсон үед хотын захиргааны дүрвэх байр луу дүрвэх

Заавал шалгах

※ Гамшгийн эрсдэлийн зураг гэж юу вэ? Хөрсний нуралт, суулт мөн усанд автах эрсдэлтэй хэсгийг өнгө будгаар ялгасан газрын зургийг хэлдэг. Будгаар тэмдэглэгдээгүй ч аюулд өртөж болно.

Өнгөөр ялгаагүй ч Г гэрийн эргэн тойронд нь том эрэг байдаг. Эсвэл Г гэрт нь нам дор газар байдаг. Бол сэрэмжлүүлэг сонсоод дүрвэх шаардлагатай.

Хөрснөөс үүдэлтэй аюул

Маш бат бөх хийцлэл бүхий өндөр барилгын дээд давхарт амьдардаг бол аюулгүй байж болох юм.

Үер усны аюул

- ① Үерийн бүсээс гадна амьдардаг бол
 - ② Усанд автахад өндөр түвшинд амьдардаг бол
 - ③ Усанд автсан ч үс татартал хэрэглэх хүнстэй бол
- Дээрх ①②③-ийн үед орон гэр аюулгүй байх магадлалтай.

Аюулгүй газарт амьдардаг найз бий юу?

Тийм

Үгүй

Анхааруулах түвшин **3** болсон үед найзын гэр лүү дүрвэх

Анхааруулах түвшин **3** болсон үед хотын захиргааны дүрвэх байр луу дүрвэх

Дүрвэх байранд бусдын эрх ашгийг хүндэтгэх хэрэгтэй.

Анхаарах зүйл

Авч явах зүйл

- Өөрийн нэрийг заавал бичнэ.
- Нэг цүнхэнд бүх зүйлээ хийнэ.

Дүрэм журам

- Бүгд хамтран аливаа ажлыг хийнэ. Жишээ нь бие засах газрын цэвэрлэгээ, хоол бэлдэх, усанд явах зэрэг
- Усны нөөц бага байх магадлал бий тул усаа ариг гамтай хэрэглэх.
- Хөгжлийн бэрхшээлтэй болон жирэмсэн болон тусламж хэрэгтэй хүнд туслах.
- Хувийн орон зайд халдахгүй байх.
- Хогоо зааврын дагуу хаях.
- Бие засах газраа цэвэрхэн ашиглах.
- Өөрөө өөрийнхөө аюулгүй байдлыг хангах.
- Буруу үйлдэл хийж буй хэн нэгнийг харвал хотын захиргааны ажилтанд мэдэгдэх.
- Хоргодох байрнаас явах болсон үед хотын захиргааны ажилтанд мэдэгдэх.
- Тамхи татахыг хориглоно. Зөвшөөрөгдсөн газарт тамхи татна.



Соёлтой байх

- Ус болон хүнсний зүйл тараахад дараалалын журам баримтална.
- Өөрийнхөө эргэн тойрныг цэвэрхэн байлгана.
- Гутлаа тайлна.
- Амьтантай байхдаа дургүйцэх хүн байж болох тул энэ тал дээр бусдыг хүндлэх.



Хоолны хордлого

- Хоолны хордлого бүтэн жилийн туршид хэзээ ч тусаж болох эрсдэлтэй тул гараа сайн угаах.
- Хоол идсэний дараа сав суулгаа сайтар угаах.



Халдварт өвчнөөс сэргийлэх

- 3 бөөгнөрөл (хаалттай, хүн ихтэй, шууд харьцдаг) зэрэг орчинд орохгүй байх.
- Гараа угаах, хоолой амаа зайлах, гараа ариутгах.
- Ашигласан салфетка хаяхдаа гялгар уутанд хийж боож хаях.
- Халуунтай эсвэл суулгалттай үед хоргодох байрны ажилтанд энэ талаар мэдэгдэх.



Биеийн байдлаа хянах

Онгоцоор олон цаг зорчсоноос болж үүсдэг :

Олон цаг хөдөлгөөнгүй байснаас болж хөлний цусны эргэлт мууддаг.

Хөлийн судсанд цусны бүлэгнэл үүснэ. Судасны эргэлт муудна.

Үүнээс сэргийлж суугаа байхдаа ч гэсэн хөлний хуруугаа хөдөлгөх ба ус ууна.

Нарших:

Зун нарших тохиолдол их байдаг. Хөлсөөр шингэнээ их хэмжээгээр алдсанаас болж эрдэсийн дутагдалд орно. Нүд эрээлжлэх, толгой эргэх, бөөлжис цутгах, амьсгаа давхцах, ухаан алдах зэрэг шинж тэмдэгтэй. Шингэн нөхөхийн тулд ус уух ба давс бага хэмжээгээр хэрэглэнэ. Гадуур гарахдаа шүхэр барих болон малгай өмсөх хэрэгтэй.



Дүрвэх байр

Цахим хуудаснаас цахим хэлбэрт оруулсан дүрвэх байрны байршлийг үзэх.

Оршин суугаа дүүргийн хамгийн ойр байрлах дүрвэх байр болон аюултай газрын талаарх мэдээлэл бий.

Дүрвэх байрны байршлын талаарх цахим мэдээлэл

Япон хэл



Англи хэл



Хятад хэл



Вьетнам хэл



Гал түймрийн үед хэрэглэгддэг япон хэлний үг хэллэг

Газар хөдлөх

Япон хэл	Галиг	Монгол хэл
震度	Shindo	Газар хөдлөлтийн хэмжээ
倒壊	Toukai	Барилга нурах
立ち入り禁止	Tachi Iri Kinshi	Орж болохгүй
断水	Dansui	Ус ашиглаж болохгүй
停電	Teiden	Тог ашиглаж болохгүй
ガス漏れ	Gasumore	Газ алдагдана
復旧	Fukkyu	Хэвийн болох

Хоргодох байр

Япон хэл	Галиг	Монгол хэл
給水車	Kyusuisha	Усны машин
給水場所	Kyusuibasho	Ус түгээх газар
被災者	Hisaisha	Гамшигт нэрвэгдэгч
救護所	Kyugosho	Тусламж үзүүлэх газар
食糧配給	Shokuryo Haikyu	Хүнсний зүйл тараах
炊き出し	Takidashi	Хоол хийж тараах

Тайфү

Япон хэл	Галиг	Монгол хэл
台風が上陸する	Taifu ga Jorikusuru	Хар салхи эх газарт ирэх
台風の進路	Taifu no Shinro	Тайфү-ний чиглэл
河川の増水	Kasen no Zosui	Голын ус огцом нэмэгдэх
河川の氾濫	Kasen no Hanran	Гол мөрөн халих
堤防の決壊	Teibo no Kekkai	Далан эвдрэх
危険水位	Kiken Sui'i	Голын ус халих түвшин
浸水	Shinsui	Усанд автах

Авто тээвэр

Япон хэл	Галиг	Монгол хэл
運休	Unkyu	Автобус болон галт тэрэгний хөдөлгөөн зогсох
欠航	Kekko	Усан болон агаарын тээвэр зогсох
通行止め	Tsuko Dome	Зам хаагдах
迂回路	Ukairo	Тойруу зам
運転見合わせ	Unten Miawase	Автобус болон галт тэрэг түр зогсох